

## **БНСУ-ЫН ШИНЭ УДИРДЛАГА**

БНСУ-ын ерөнхийлөгчийн 17 дахь удаагийн сонгууль өнгөрсөн 2007 оны 12 дугаар сарын 19-нд явагдсан байна. Ерөнхийлөгчийн сонгуульд нийт 23 сая 732 мянга 854 саналын хуудас тоолсноос 11 сая 492 мянга 389 санал буюу 48.7%-ийн санал авч БНСУ-ын 17 дахь ерөнхийлөгчөөр И Мён Бак итгэл төгс сонгогдов. Тэрээр ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсны дараа өөрийн нам болох болох ХАННАРА /Нэг улс/ намын байранд сэтгүүлчдэд ярилцлага өгөхдөө маш дарууханаар мөн өөртөө итгэлтэйгээр “Би ард түмнээ асран халамжлах болноо” гэж хэлсэн байна. Тус улстай Монгол Улс дипломат харилцаа тогтоосны 17 жилийн ой энэ жил тохиож байна. БНСУ нь манай улсын дөрөв дэх том хөрөнгө оруулагч улсын хувьд тус орны шинэ засгийн газрын бүрэлдэхүүнээр хэн гэдэг субъектүүд сонгогдсон нь манай орон тус улс харилцах харилцаанд нэгээхэн ач холбогдолтой билээ. Иймээс тус орны шинээр байгуулагдсан засгийн газрын сайдуудын танилцуулгыг дор үзүүлэв .

### **И Мён Бак - Lee Myung Bak БНСУ-ын Ерөнхийлөгч**

БНСУ-ын 17 дахь ерөнхийлөгчөөр сонгогдсон И Мён Бак нь 1941 оны 12-р сарын 19-нд Японы Осака хотод төрсөн байна. Түүний мэргэжил нь улс төр судлаач бөгөөд өмнө нь парламентийн гишүүнээр сонгогдож байв. Тэрээр Солонгосын хамгийн том улсын өмчит Хёндай группын ерөнхийлөгч, Сөүл хотын захирагчаар ажиллаж байсан бөгөөд энэ ажиллаж байх хугацаандаа Сөүл хотын хөгжлийн төлөө ихээхэн зүйл хийсэн нь ерөнхийлөгчөөр сонгогдоход ихээхэн нөлөөсөн байна. Мөн И ерөнхийлөгч урьд нь Сөүл хотын захирагч байхдаа манай улсад айлчилж байсан бөгөөд Монгол Улсын Их Сургуулийн хүндэт доктор цолыг хүртсэн байна.

### **Хан Син Сү – Han Sin Su БНСУ-ын Ерөнхий сайд**

БНСУ-ын 39 дэх ерөнхий сайдаар томилогдсон Хан Син Сү нь 1936 оны 12-р сарын 28-нд Солонгосын Кангвон аймагт төрсөн байна. Тэрээр урьд нь засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллаж байсан улс төрийн ажилд туршлагатай нэгэн юм. Түүнд Солонгосын ард түмэн ихээхэн итгэл өгч байна. Тэрээр ялангуяа гадаад салбарт ихээхэн нэр хүндтэй бөгөөд НҮБ-д улс орноо нэр хүндтэйгээр төлөөлөн ажиллаж байсныг нь үнэлж дипломат цол өргөмжлөл мөн Солонгос-Англи улсын хоорондох харилцаанд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэснийг нь үнэлж Англи улсын хүндэт шагналыг тус тус хүртэж байсан байна.

### **Юу Мен Хуан - Yu Myung Hwan Гадаад Хэргийн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1946.04.08

Мэргэжил: Гадаад харилцааны мэргэжилтэн

Боловсрол: Нидерландын Нийгмийн Шинжлэх Ухааны институт, Сөүлийн Их Сургуулийн хууль эрх зүйч болон төр захиргааны удирдлага судлал.

Ажлын туршлага: Гадаад хэргийн яамны сайд, Япон дахь Солонгосын элчин сайд, Гадаад Хэргийн Яамны 1-р нарийн бичгийн дарга.

### **Ким Кен Хан - Kim Kyung Han**

#### **Хууль Зүйн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1944.02.05

Боловсрол: АНУ-ын Жоржтауны Их Сургууль болон Сөүл Их Сургуулийн хууль эрх зүйн магистр

Ажлын туршлага: Хууль зүйн яамны сайд, Дүсан компанийн гадаад харилцаа хариуцсан захирал, Хайникс компанийн гүйцэтгэх захирал.

### **Ли Сан Хи - Lee Sang Hee**

#### **Батлан Хамгаалах Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1945.08.12

Мэргэжил: Хуурай замын цэргийн удирдлага

Боловсрол: Хуурай цэргийн 26-р сургууль

Ажлын туршлага: БХЯ-ны сайд, 132-р ангийн захирагч, хуурай замын 3-р ангийн захирагч

### **Чунг Жонг Хуан - Chung Jong Hwan**

#### **Барилга, Зам тээврийн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1948.07.30

Мэргэжил: Төрийн албан хаагч

Боловсрол: АНУ-ын Вашингтоны Их Сургуулийн эдийн засгийн магистр, Сүн Чон Хян Их Сургуулийн хүндэт доктор

Ажлын туршлага: Нутаг дэвсгэр, Далайн яамны сайд, Солонгосын төмөр замын угсрах үйлдвэрийн дэд дарга

### **Ким Ду Ён - Kim Doh Yeon**

#### **Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1952.03. 14

Мэргэжил: Сурган хүмүүжүүлэгч /багш

Боловсрол: Франц улсын “Килермунперан” Их Сургуулийн түүхий эд боловсруулалтын технологи инженер чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. Солонгосын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг түүхий эдийн технологичийн магистрийн зэрэг хамгаалсан.

Ажлын туршлага: Японы Токиогийн Их Сургуульд багш, Солонгосын Техник, Инженерийн төвийн дэд тэргүүний албыг тус тус хашиж байсан байна.

**Вон Си Хун - Won Sei Hoon****Төр Захиргааны Аюулгүй Байдлын Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1951.01.31

Мэргэжил: төр захиргааны ажилтан

Боловсрол: Сөүлийн Их Сургуулийн Удирдлагын сургуулийн менежмент, Ханяан Их сургуулийн төр захиргааны удирдлагын магистр

Ажлын туршлага: Төр захиргаа Аюулгүй Байдлын Яамны сайд,

Байгаль орчныг хамгаалах ОУ-ын байгууллагын гишүүн /2006-2009/, Сөүл хотын орлогч дарга.

**Ким Сонг И - Kim Soung Yee****Эрүүлийг Хамгаалах, Нийгэм Хангамж, Гэр бүлийн Яам**

Төрсөн он сар өдөр: 1946.12.05

Мэргэжил: Багш

Боловсрол: АНУ-ын Юта Их Сургуулийн Нийгэм судлалын доктор, Сөүл Их Сургуулийн магистр

Ажлын туршлага: Ханнара намын дунд шатны сонгуулийн хорооны дарга.

**Ли Ён Хи - Lee Young Hee****Хөдөлмөрийн Яам**

Төрсөн он сар өдөр: 1943.07.19

Мэргэжил: Багш

Боловсрол: Сөүл Их Сургуулийн Хууль эрх зүйн магистр, Герман улсын БУКОМ Их Сургууль

Ажлын туршлага: Хөдөлмөрийн Яамны сайд, “Ёиду” хүрээлэнгийн захирал.

**Юу Ин Чон - Yu In Chon****Соёл, Биеийн тамир, Аялал жуулчлалын Яамны Сайд**

Төрсөн он сар өдөр: 1951.03.20

Мэргэжил: Жүжигчин

Боловсрол: Ёнсэй Их Сургуулийн Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны анги, Жүнан Их Сургуулийн Телевизийн жүжиг, кино драмын магистр

Ажлын туршлага: Соёл, Биеийн тамир, Аялал жуулчлалын Яамны Сайд, 17 дахь удаагийн ерөнхийлөгчийн нийгэм боловсрол соёлын хорооны гишүүн

**Чонг Үн Чон - Chong Un Chon****Газар тариалан, загасны аж ахуйн бүтээгдэхүүний Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1954

Мэргэжил: Бизнес

Боловсрол: Корё Их Сургуулийн Тариалангийн эдийн засгийн анги  
Ажлын туршлага: Хөдөө аж ахуй, Хүнсний бүтээгдэхүүний Яамны сайд,

Чоннам Их Сургуульд багш, Солонгосын Газар Тариалагийн Холбооны тэргүүн

**Ли Ён Ху - Lee Youn Ho**  
**Эдийн Засгийн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1948.01.18

Мэргэжил: Судлаач

Боловсрол: АНУ-ын Весконы Их Сургуулийн эдийн засгийн бакалавр,  
 мөн Медисоны Их Сургуулийн төр захиргааны удирдлагын магистр

Ажлын туршлага: Улсын эдийн засгийн холбооны тэргүүн, дэд тэргүүн

**Кан Ман Су - Kang Man Soo**  
**Төлөвлөгөө, Санхүүгийн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1945.06.30

Боловсрол: АНУ-ын Нью-Йорк Их Сургуулийн Эдийн засгийн  
 магистр, Сөүлийн Их Сургуулийн хууль эрх зүйн бакалавр

Ажлын туршлага: Ханнара намын дунд шатны сонгуулийн хорооны  
 зохион байгуулах дарга, 17 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн  
 эдийн засаг хариуцсан дарга

**Нам Жү Хон - Nam Joo Hong**  
**Эв нэгдлийн Яамны сайд**

Төрсөн он сар өдөр: 1952.07.16

Мэргэжил: Багш

Боловсрол: Английн Олон улсын улс төр судлалын доктор, Английн  
 Эбордийн Их Сургуулийн Эрчим хүч Судлалын магистр

Ажлын туршлага: Кёнги Их Сургуулийн Улс төр судлалын сургуулийн  
 захирал

**Эх сурвалжууд**

- Ханин Шинмүн /сэтгүүл 2008.02.25 –ны дугаар/
- Гугүг Сушиг /сэтгүүл 2008 оны 2-р дугаар/
- “Хөх толбо” сонин 2007 он №14
- [www.yonhapnews.co.kr](http://www.yonhapnews.co.kr)
- [www.naver.com](http://www.naver.com)
- [www.daum.net](http://www.daum.net)
- [www.chosun.com](http://www.chosun.com)
- [www.president.go.kr/](http://www.president.go.kr/) БНСУ-ын ерөнхийлөгчийн электрон хаяг/

*Мэдээ бэлтгэсэн Н.Бямбадорж (ОУСХ-ийн  
 эрдэм шинжилгээний ажилтан)*